



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 1/500

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын багш нарын өдрийн үйл ажиллагааны зардалд 3,000,000 (Гурван сая), Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 100 жилийн ойг тохиолдуулан тус сургуулийн багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд 6,000,000 (Зургаан сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 9,000,000 (Есөн сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Д.Балжинням) нарт зөвшөөрсүгэй.

3. Монголын багш нарын өдрийн үйл ажиллагааны зардлын дэмжлэг 3,000,000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дансанд, багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны дэмжлэг 6,000,000 (Зургаан сая) төгрөгийг Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн дансанд тус тус шилжүүлэхийг нягтлан бодогч (Д.Балжинням)-д даалгасугай.

4. Дэмжлэгээр олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ш.Отгон-Эрдэнэ), Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн захирал (Б.Гантулга) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

